

ШИЛЖҮҮЛЭХ ЗАНГИЛАА №2, /УП-2/ СУУРЬ ХҮЧИТГЭХ ЗУРАГ, ТӨВ АГУУЛАХ №2-ИЙН ДЭЭВРИЙН ИХ ЗАСВАРЫН БОЛОН ҮНДСЭН ХАНАНД ҮЗЛЭГ ХИЙН ДҮГНЭЛТ ГАРГАН ХҮЧИТГЭЛИЙН ЗУРАГ, ТУРБИН ЗААЛНЫ А РЯДЫН ЦОНХ ШИНЭЧЛЭН ЗАСВАРЛАХ, ХҮЧИТГЭХ АЖЛЫН ЗУРАГ ХИЙЛГЭХ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ, МАГАДЛАЛЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№ 4/2021-233

2021 он 5 дугаар сарын 31-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “ДЦС-4” ТӨХК-г төлөөлж ХААХ-ийн дарга В.Лхагвадорж /цаашид захиалагч гэх/, нөгөө талаас “ММ АРХИТЕКТУР” ХХК-ийн захирал Б.БААСАНЖАВ цаашид гүйцэтгэгч гэх/ нар хамтад нь /цаашид талууд гэх/ нар нь Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийг 29.1, МУ-ын иргэний хуулийн 343-357-р зүйлийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг.Нийтлэг зүйл

Энэхүү гэрээний зорилго нь “Шилжүүлэх зангилаа №2, /уп-2/ суурь хүчитгэх зураг, төв агуулах №2-ийн дээврийн их засварын болон үндсэн хананд үзлэг хийн дүгнэлт гарган хүчитгэлийн зураг, турбин заалны а рядын цонх шинэчлэн засварлах, хүчитгэх ажлын зураг хийлгэх, төсөв боловсруулах, магадлалын ажил гүйцэтгэх” ажлыг дор дурьдсан хугацаанд, чанартай материалаар гүйцэтгэж захиалагч талд хэвийн ажиллагааг хангаж хүлээлгэж өгөх, Захиалагч нь гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохирсон хэлбэр, хугацаанд ажлын хөлсийг төлөх, засварын ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1. Ажил гүйцэтгэх хугацааг тогтоохдоо календарийн /хуанлийн/ ажлын өдрийг удирдлага болгоно.
- 2.2. Гэрээний хугацаа нь талууд гарын үсэг зурснаас хойш **60** /Энэ хоногт магадлалын хугацаа орсон/ хоногт багтаан гүйцэтгэнэ.
- 2.3. Хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний гүйцэтгэлийн хугацааг сунгаж болно.

Гурав. Төлбөр тооцоо

- 3.1 Гэрээт ажлын материалтай үнэ нь харьцуулалтын тендер шалгаруулалтаар гүйцэтгэгч тодруулахад шалгарсан үнэ болох **39,200,000₮** /Гучин есөн сая хоёр зуун мянга/ төгрөг байхаар талууд харилцан тохиролцов Энэ үнэд хуулийн 28.6-р зүйлд зааснаар НӨАТ, татвар, даатгалтай холбогдсон бүх зардлууд багтсан болно./
- 3.2 Төлбөр тооцоог дараахь хүснэгтэнд заасан журмаар санхүүжүүлнэ. Үе шатны гүйцэтгэл бүрийг гаргаж нэхэмжлэх бичнэ.

№	Гүйцэтгэсэн байвал зохих хувь	Нэхэмжлэх мөнгөн дүн /%/	Төлбөр хийгдэх хугацаа	Тайлбар
1	Ажлын урьдчилсан гүйцэтгэл гаргах шаардлагагүй	Урьдчилгаа өгөхгүй	Нэхэмжлэлд гарын үсэг зурснаас хойш 21 хоногт	Гүйцэтгэсэн ажлын хэсэгчилсэн гүйцэтгэл гаргаж талууд гарын үсэг зурсан байна
2	Ажлыг бүрэн дуусгаж, бүх баримт бичгийг бүрдүүлж, талууд гэрээг дүгнэн актанд гарын үсэг зурж баталгаажуулна	100% буюу 39,200,000.00₮		Ажлын эцсийн гүйцэтгэл баталгаажуулж, засварын акт формуляр холбогдох баримт бичиг 100% бүрдсэн, гэрээг дүгнэн төлбөр тооцооны эцсийн шийдвэр гарсан байна.

- 3.3 Гүйцэтгэгч нь гэрээгээр гүйцэтгэх ажлыг бүрэн гүйцэтгэж Захиалагч талд бүрэн хүлээлгэн өгсөн, хүлээн авсан тухай гэрээ дүгнэсэн актанд хоёр талын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсгээ зурж баталгаажуулсны дараа гүйцэтгэгч тал төлбөрийн албан ёсны нэхэмжлэлээ захиалагч талын санхүүд албан ёсоор хүлээлгэн өгсөн өдрөөс хойш ажлын 21 өдрийн дотор нийт гүйцэтгэлийн үнийн дүнгээр санхүүжүүлнэ.
- 3.4 Төлбөр тооцоог бодит гүйцэтгэлээр хийнэ.

Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх

- 4.1. Гүйцэтгэгч нь гэрээгээр гүйцэтгэсэн ажил үүргээ гүйцэтгэж дууссаны дараа гүйцэтгэсэн ажлын хэмжээнд тохирсон хөлсөө акт баримт бичгийг бүрдүүлж, баталгаажуулж, албан ёсны нэхэмжлэлийг захиалагчид өгснөөс хойш шаардах эрхтэй.
- 4.2. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэх явцад Захиалагч талыг төлөөлөн, шийдвэр гаргах, санал солилцох, хяналт тавих, эрх бүхий этгээдийг томилуулан авах эрхтэй.
- 4.3. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардагдах доорх бичиг баримтыг Захиалагч талаас авах эрхтэй. Үүнд:
1. Мэргэжлийн эрх бүхий байгууллагын гаргасан техникийн дүгнэлт
 2. Зураг төсөл боловсруулах даалгавар.
 3. Хүчитгэх, засварлах барилга, байгууламжийн ажлын зураг.
 4. Хүчитгэх, засварлах барилга, байгууламжийн инженер геологийн дүгнэлт.
- Дээрх бичиг баримтын 1-4 дугаар бүрдлийг Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш хуанлийн 5 хоногт багтаан гүйцэтгэгчид өгнө.
- 4.4. Гэрээний 4.3. заасан Захиалагч талаас Гүйцэтгэгч талд хүлээлгэн өгөх бичиг баримтын бүрдэл, хүлээлгэн өгөх хугацаа нь гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаатай шууд хамааралтай байна.

Тав. Гүйцэтгэгчийн үүрэг

- 5.1 Барилгын ба инженерийн шугам сүлжээний ажлыг баталгаажсан зураг, төсөв, барилгын норм дүрэм, стандартын дагуу чанартай засаж, гэрээнд заасан хугацаанд ашиглалтанд оруулан захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 5.2 Буруу буюу дутуу хийсэн ажлаа тухай бүр өөрийн хөрөнгөөр засаж гүйцээх, ажлын явцад илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгахын хамт гүйцэтгэлийн зураг гаргах, шаардлагатай тохиолдолд магадлалаар оруулах үүрэгтэй.
- 5.3 Хэрэв барилга угсралтын явцад гүйцэтгэсэн ажлын чанарт дутагдал гарвал харилцагч талууд комисс гарган доголдлын шалтгааныг тодорхойлж буруутай тал нь ажлын 14 хоногийн дотор өөрсдийн хөрөнгөөр засаж хэвийн ажиллагаанд оруулж хүлээлгэн өгөх

үүрэгтэй ба шаардлагатай тохиолдолд хүсэлт гаргаснаар талууд харилцан тохиролцож хугацааг сунгаж болно.

- 5.4 Ажлын зураг, төсвийг хянуулах, баталгаажуулах явцад Барилгын хөгжлийн төвийн магадлалын хэлтсээс өгсөн шаардлагыг биелүүлж, гүйцэтгэх үүрэгтэй.
- 5.5 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэсний дараа, дараах бичиг баримтыг 1% эх, 3% хуулбар, тоон хэлбэрээр PDF өргөтгөлөөр 1% бүрдүүлэн хүлээлгэн өгнө.

Үүнд:

1. Ажил гүйцэтгэх гэрээ /хуулбар/.
 2. Захиалагчаас авсан бичиг баримт /хуулбар/
 3. Магадлалын ерөнхий дүгнэлт, хавсралтуудын хамт
 4. Ажлын зураг төсөл хүлээлцсэн акт
 5. Гэрээ дүгнэсэн акт
 6. Иж бүрэн батлагдсан ажлын зураг
 7. Экспертизээр хянагдсан барилгын иж бүрэн төсөв
- 5.6 Гүйцэтгэгч нь гэрээт ажлын хугацаанд гэрээт ажилтай холбоотой ажил үүргийн асуудалд өөрийн ажилтнуудын нийгмийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг бүрэн хариуцна.
- 5.7 Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хангах, болзошгүй тохиолдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас ажилтанд учирсан хохирлыг нөхөн төлөх, амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах зардлыг төлөвлөж хэрэгжүүлнэ.
- 5.8 Гүйцэтгэгч байгууллагын ажилтан осолд орсон тохиолдолд “Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу судлан бүртгэх, залруулах арга хэмжээний зардлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.
- 5.9 Гүйцэтгэгч нь ажилчдаа хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийн зөрчилгүй ажилуулах, аюулгүй ажиллагааг бүрэн хариуцах үүрэгтэй.
- 5.10 Гүйцэтгэгч нь захиалагчийн төлөөлөгч, техникийн удирдлага болон эрх бүхий улсын байцаагч нарын тавьсан шаардлагыг бүрэн биелүүлж хариуг бичгээр буюу амаар цаг тухайд нь мэдэгдэж байх үүргийг хүлээнэ.
- 5.11 Гүйцэтгэгч нь өөрийн компанийн онцлогийг харуулсан эмблем бүхий Захиалагч талын ажиллагсадаас ялгарахуйц ажлын тусгай хувцастай байна.

Зургаа. Захиалагчийн эрх

- 6.1. Гэрээт ажлыг гүйцэтгэх явцад буюу Засварын зураг БХТ-д хянуулж батлуулахаас өмнөх үе шатанд өөрийн томилогдсон төлөөлөгчөөр дамжуулан санал тусгах, өөрчлүүлэх эрхтэй.
- 6.2. Гэрээт ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулах бөгөөд барилгын холбогдох норм, стандартыг зөрчиж буруу, дутуу, чанаргүй хийсэн ажлыг засуулах, гүйцээж хийхийг шаардах ба уг шаардлагыг биелүүлэх хүртэл санхүүжилтийг зогсоох эрхтэй.
- 6.3. Гэрээт ажлын гүйцэтгэлийг үе шатны мэдээлэл авах, хугацаанд гүйцэтгүүлэх, ажлын баримт бичиг бүрдүүлэх зэрэгт шаардлагатай мэдээлэллүүдийг цаг тухайд нь гаргуулах эрхтэй.

- 6.4. Барилгын зураг боловсруулах, төсөв зохиох явцад ашиглах материал, хийц эдлэлийн бүрдэлд томилсон төлөөлөгчөөрөө дамжуулан санал тусгах эрхтэй.
- 6.5. Зураг төсөв, барилгын норм дүрэм, стандартыг зөрчсөн, чанарын гологдол гаргасан, санхүүжилтийг зориулалтын бусаар ашигласан, материал, тээвэр, механизмын зардал, үнийн зөрүүг буруу тооцсон тохиолдолд Захиалагч нь эрх бүхий байгууллага, хүмүүсээр хянуулж торгууль ноогдуулах ба гарсан хохирол, зардлыг гүйцэтгэгчээр төлүүлэх, шаардлагатай бол байгуулсан гэрээг цуцлах эрхтэй.
- 6.6. Хяналтын албаны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, эсэргүүцсэн тохиолдолд гэрээг цуцлуулах хүртэл арга хэмжээ авах эрхтэй

Долоо. Захиалагчийн үүрэг

- 7.1. Зураг төсөл боловсруулах эдэлбэр газрын холбогдох бичиг баримт, байгаль орчны үнэлгээ, архитектур төлөвлөлтийн даалгавар, дэвсгэр зураг, инженер геологийн дүгнэлт, цахилгаан, дулаан, цэвэр бохир усан хангамж, холбооны инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөл болон бусад холбогдох баримт материалыг, талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш хуанлийн 21 хоногт гүйцэтгэгчид өгсөн байх үүрэгтэй.
- 7.2. Гүйцэтгэгчээс үл хамаарах нөхцөл байдлын улмаас барилгын ажлын зураг төслийг зогсоох шаардлага гарвал ажлын гүйцэтгэлийг хянаж тооцоог гарган, гүйцэтгэсэн ажлын хэмжээнд тохирох төлбөрийг төлөх үүрэгтэй.
- 7.3. Захиалагч тогтоосон журмын дагуу гүйцэтгэгчээс иж бүрэн ажлын зураг төслийг актаар хүлээн авч, санхүүжилтийг өгөх үүрэг хүлээнэ.
- 7.4. Гүйцэтгэгчийн ажиллагсад хулгай хийсэн болон хулгайн хэрэгт холбогдсон нь тогтоогдвол захиалагчийг хохиролгүй болгож, хулгайлсан эд зүйлийн үнийн дүнг 3 дахин өсгөсөн үнээр захиалагчид торгууль төлөх бөгөөд энэ зөрчил дахин давтагдвал уг гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах эрхийг захиалагч эдэлнэ.

Найм. Талуудын хүлээх үүрэг хариуцлага

- 8.1 Гүйцэтгэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол гэрээнд урьдчилан заасан хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн **0.1%**-ийн алдангийг захиалагч талд төлнө.
- 8.2 Захиалагч тал гэрээнд заасан төлөх ёстой төлбөрийг гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн **0.1%**-ийн торгууль гүйцэтгэгчид төлнө.
- 8.3 Торгууль, алданги төлсөн нь үндсэн үүрэг болон учирсан хохирлыг төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 8.4 Захиалагчийн саналаар нэмэгдэл ажил хийгдэх, төсөвт ажилбар, материал, тээвэр, механизмын зардал дутуу тусгагдсан, үнийн зөрүү гарсан тухай бүр хоёр тал харилцан тохиролцож акт протокол байгуулан баталгаажуулж шийдвэрлэнэ.
- 8.5 Талууд зураг төсөл боловсруулахад шаардагдах Архитектур төлөвлөлтийн даалгавар батлуулах, Загвар зураг төсөл батлуулах, Гадна инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөл авах ажилд хамтран ажиллана.

Ес. Давагдашгүй хүчин зүйл /Форс мажор/

- 9.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг нь энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 9.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй болсон бол талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээт хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу нэг талын санаачлагаар цуцлана.
- 9.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд Форс мажорын нөхцөлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

Арав. Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах

- 10.1 Энэхүү гэрээнд заасан үүргээ талууд ноцтой зөрчсөн буюу хуульд заасан үндэслэл бий болсон бол талууд хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.
- 10.2 Хэрвээ талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал урьдчилан тохиролцон хавсралтаар оруулж гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээний нэг адил хууль зүйн хүчинтэй.

Арван нэг. Бусад зүйл


- 11.1 Энэхүү гэрээний үйлчлэл нь талууд гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болж, талууд тус тусын үүргээ биелүүлж баталгаат хугацаа дууссанаар дуусгавар болно.
- 11.2 Талууд энэхүү гэрээг 4 хувь үйлдэж захиалагч 3%, гүйцэтгэгч 1% хувийг хадгалах ба тус бүр нь хууль зүйн адил хүчинтэй.
- 11.3 Талууд энэхүү гэрээгээр тохиролцсон үйлчлэх хүрээ, цаг хугацаа, нөхцөлийг дур мэдэн өөрчлөх эрх эдлэхгүй.
- 11.4 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх болон хүчин төгөлдөр байх хугацаанд гарч болох бүх маргаан зөрчил зэргийг харилцан тохиролцож шийдэх ба үл тохиролцсон тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 11.5 Энэхүү гэрээг биелүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрчилдөөнийг зөвшилцөл, хэлцэл хийж аль болох эвийн журмаар шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Захиалагч талыг төлөөлж:

“ДЦС-4” ТӨХК-ИЙН
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД ЕРӨНХИЙ
ИНЖЕНЕР


Б.ГАНХУЯГ
25/2



Гүйцэтгэгч талыг төлөөлж:

“ММ АРХИТЕКТУР” ХХК-ИЙН
АРХИТЕКТОР  Э.СОДМАНДАХ

СБХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НИЯГТЛАН
БОДОГЧ  Д.ТӨМӨРТОГОО

ТЭЗХ-ИЙН ДАРГА  Ж.ОТГОН


ХА-НЫ ДАРГА  Д.ӨСӨХБАЯР

ХААХ-ИЙН ДАРГА  В.ЛХАГВАДОРЖ

НАХ-ИЙН ДАРГА  Б.ТӨРБАТ


ХУУЛИЙН ЗӨВЛӨХ  Ч.БЯМБАСҮРЭН

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН С. ДОНИД

 ХОЁР ТАЛЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

Монгол улс, 16100 Улаанбаатар хот
Баянгол дүүрэг, 20 дугаар хороо
“ДЦС-4” ТӨХК
Утас: 7018-1309, Факс: 7000-137

Гүйцэтгэгчийн хууль ёсны хаяг, утас,
факс: УБ хот, БГД, 3-р хороо, Энгельсийн
гудамж Нарны хороолол, 28-106 тоот
РД: 6062652
Утас 99108632, 77111002
Банк: Худалдаа хөгжлийн банк
Данс: 427005939

БАТЛАВ: ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД
 ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  Б.ГАНХУЯГ.

Шилжүүлэх зангилаа №2 (УП2) суурийн хүчитгэлийн зураг хийх, Төв агуулах №2-ийн дээврийн их засварын болон үндсэн хананд үзлэг хийж дүгнэлт гарган хүчитгэлийн зураг хийх, Турбин цехийн заалны А рядын цонхны рамыг шинэчлэн засварлах, хүчитгэлийн зураг хийх ажлын даалгавар.

2020 оны 05-р сарын 16 өдөр

Улаанбаатар хот.

1	Захиалагчийн нэр.	"Дулааны 4-р цахилгаан станц" ТӨХК /ДЦС-4 ТӨХК/
2	Захиалагчийн хаяг.	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Эрчим хүчний гудамж, өөрийн байр, ШХ-37, ЗИП код: 16101
3	Зураг төслийг боловсруулах үндэслэл.	ДЦС-4 ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын баталсан 2021 оны Барилга засварын төлөвлөгөө.
4	Зорилго.	<ol style="list-style-type: none"> 1. Барилгын үндсэн хийц бүтээцийн ашиглалт, эдэлгээнд судалгаа хийж дүгнэлт гаргах, гэмтэлд орсон хийцүүдийг хүчитгэх засварын зураг төсөл, шийдлийг эдийн засгийн хэмнэлттэй, норм дүрмийн дагуу боловсруулахад оршино. 2. Гулзайлтанд орсон цонхны рамыг шинээр хүчитгэж засварлах. 3. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын албан шаардлагын дагуу зөрчил дутагдлыг арилгах.
5	Ажлын даалгавар	<p><u>Баримт бичгийн иж бүрдэл</u></p> <ul style="list-style-type: none"> - Барилгын гадна дотор үзлэг, шинжилгээ хийж барилгын үндсэн болон бусад хийцүүдэд дүгнэлт гаргах - Гэмтэлд орсон хийцүүдийг хүчитгэх, засварын ажлын зураг төсөл боловсруулж төсөв хийх. - Гулзайлтанд орсон цонхны рамыг шинээр хүчитгэж ажлын зураг гаргах. - Дээврийн хучилтын хийцлэлийг шинэчилэх ажлын зураг гаргах. - Барилгын тоосгон ханыг шалгаж дүгнэлт гаргах, бэхэлгээ хийх ажлын зураг гаргуулах. - Барилга ашиглалтын заавар боловсруулах. - Зураг төсөлд магадлал хийлгэх. - Магадлалын ерөнхий дүгнэлт / Хавсралт дүгнэлтийн хамт / <p><u>Ажлын зургийн иж бүрдэл</u></p> <ul style="list-style-type: none"> - Ажлын зураг / Батлагдсан, Файлаар/ - БА-Барилга архитектур /Файлаар/ - ТЕ- Технологийн зураглал /Файлаар/ - ББ- Барилга бүтээц /Файлаар Бүтээцийн тооцооны хамт /
6	Барилга байгууламжийн байршил.	<p>ДЦС-4 ТӨХК-ний хашаан дотор</p> <ul style="list-style-type: none"> - ТДЦ-ийн УП2-ийн Галлерейн төмөр бетон баганын суурь - ХААХ-ийн Агуулах №2-ын байр - Үйлдвэрийн төв байрны Турбин заал
7	Судалгаа хийн дүгнэлт гаргаж, хүчитгэлийн зураг хийх хийц элементүүд	<p><u>Шилжүүлэх зангилаа №2:</u></p> <ul style="list-style-type: none"> - Төмөр бетон суурьт шинжилгээ хийж дүгнэлт гаргаж хүчитгэлийн ажлын зураг гаргах.

		<p><u>Агуулах №2:</u></p> <ul style="list-style-type: none"> - Дээврийн хучилтын хийцийг шинэчлэх ажлын зураг гаргах. - Үндсэн хананд судалгаа шинжилгээ хийж дүгнэлт гаргах, булангийн хэсэгт хүчитгэл хийх ажлын зураг гаргах. <p><u>ТЦ А ряд 27-28-р баганын хоорондох цонх:</u></p> <ul style="list-style-type: none"> - Хуучин цонхны раманд үзлэг шинжилгээ хийж дүгнэлт гаргах. - Шинээр цонхны порьеом угсрах ажлын зураг гаргах.
8	Барилгын үндсэн хийц бүтээц.	<p><u>Үйлдвэрийн төв байрны Турбин залны барилга нь:</u> 1979 онд ОХУ-д хийгдсэн зураг төслөөр баригдаж 1982 оны 07-р сарын 01-нд ашиглалтанд орсон. Төмөр карказ болон, угсармал хавтан, шатдаггүй хуудсан ба хавтан материал, төмөр бетон металл хийцүүдээр хийгдсэн үйлдвэрийн барилга.</p> <ul style="list-style-type: none"> - Салхины ачаалал – 450 Н/м² - Цасны ачаалал – 500 Н/м² - Газар хөдлөлийн эрчим – 8 балл - Нийт урт - 338,6 м - Нийт өргөн – 38,5 м - Нийт өндөр – 31 м <p><u>Агуулах -2:</u> 1994 оны 07-р сарын 01-нд ашиглалтанд орсон Төмөр карказ болон, Цагаан тоосгон агуулахын барилга</p> <ul style="list-style-type: none"> - Салхины ачаалал – 450 Н/м² - Цасны ачаалал – 500 Н/м² - Газар хөдлөлийн эрчим – 8 балл - Нийт урт - 90 м - Нийт өргөн – 36 м - Нийт өндөр – 11 м <p><u>Шилжүүлэх зангилаа №2 (УП2):</u> 1979 онд ОХУ-д хийгдсэн зураг төслөөр баригдаж 1983 оны 07-р сарын 01-нд ашиглалтанд орсон. Төмөр карказ болон, угсармал хавтан, шатдаггүй хуудсан ба хавтан материал, төмөр бетон металл хийцүүдээр хийгдсэн үйлдвэрийн багууламж.</p> <ul style="list-style-type: none"> - Салхины ачаалал – 450 Н/м² - Цасны ачаалал – 500 Н/м² - Газар хөдлөлийн эрчим – 8 балл - Нийт урт - 12 м - Нийт өргөн – 12 м - Нийт өндөр – 24,8 м
9	Зураг төслийн баримт бичиг боловсруулах үе шат, хугацаа.	Гэрээнд заасан хугацаанд
10	Зураг төслийн байгууллага.	БХБЯ-наас "Барилга угсралтын зураг төсөл хийх тусгай зөвшөөрөл" авсан эрх бүхий байгууллага сонгон шалгаруулалтаар, гэрээгээр гүйцэтгүүлэх.
11	Зураг төсөл боловсруулах санхүүжилт.	ДЦС-4 ТӨХК-ийн өөрийн хөрөнгө

12	Гүйцэтгэгч байгууллага.	<ul style="list-style-type: none"> - БХБЯ-наас "Барилга угсралтын зураг төсөл хийх тусгай зөвшөөрөл" авсан эрх бүхий туршлагатай байгууллагаар гүйцэтгүүлэх. - Сүүлийн 4-н жилд дор хаяж 1 ижил төстэй гэрээ гүйцэтгэсэн байх.
13	Зураг төсөл хийхэд шаардлагатай баримт бичиг, материал.	<p>Зураг төслийг дараах баримт бичгийн дагуу гүйцэтгэнэ.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - БНБД 52-03-05 Угсармал бетон, Төмөр бетон бүтээц - БНБД 20-03-11 Барилгын бүтээц, байгууламжийг зэврэлтээс хамгаалах - БД 31-101-00 "Эвдрэл гэмтэлтэй барилга байгууламжид инженерийн биет судалгаа явуулах аргачилсан заавар УБ 2000 он" - БД 31-102-00 Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар УБ 2000 он - Шаардлагатай бусад БНБД, БД, баримт бичиг.
14	Эдийн засгийн тооцоо.	Зураг төслийн дагуу мэргэшсэн төсөвчнөөр ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох.

ТАНИЛЦСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕРИЙН ОРЛОГЧ

Р.ГАНБАТ

ХЯНАСАН:

ХА-НЫ ДАРГА

Д.ӨСӨХБАЯР.

НАХ-ИЙН ДАРГА

Б ТӨРБАТ.

ТДЦ-ИЙН ДАРГА

П.БАЯР-ЭРДЭНЭ

ТЦ-ИЙН ДАРГА

Ц.БАТМАГНАЙ.

СБХ-ИЙН ДАРГА

Д.ТӨМӨРТОГОО

С. Ан 20 107.

БОЛОВСРУУЛСАН:

НАХ-ИЙН ББЗХ-ЫН ИНЖЕНЕР

Б.БАТСҮРЭН.

НАХ-ИЙН БЧС-ЫН ТЕХНИКЧ –Г

Ө ШИЙРЭВНЯМБУУ